

**ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГ ХӨТЛӨХ,
БОЛОВСРУУЛАХ ЗААВАР**

АГУУЛГА

Нийтлэг үндэслэл

1. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг хөтлөхөд тавигдах шаардлага
2. Зурмаг хөтлөх
3. Зурмаг боловсруулах үндсэн өгөгдөл
4. Зурмагийн биелэлт тооцож бүртгэх
5. Зурмагийн тайлан
6. Зурмаг тооцох
7. Зурмагийн тасалдал бүртгэх

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү заавраар “Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг”, “Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг”-ийг хөтлөх, боловсруулах үйл ажиллагааг зохицуулна.

Төмөр замын техник ашиглалтын журмын 12.1.2, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмын 12.8 заалтуудыг болон Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмыг хэрэгжүүлэх, “Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг”-ийг хөтлөхөд зориулагдана.

Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг Төмөр замын нэгдсэн удирдлага, зохицуулалтыг хариуцсан байгууллага, дэд бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага тус тус дагаж мөрдөнө.

НЭГ. ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗУРМАГ ХӨТЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1.1. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг нь Улаанбаатарын цагаар 17:00 цагт эхэлж, дараа өдрийн 17:00 цаг хооронд хөтлөгдөнө.

1.2. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг зурах масштабчилсан тор нь босоо хэвтээ шугамуудаас бүрдэнэ. Босоо шугамаар зайг, хэвтээ шугамаар цаг, минутыг үзүүлнэ.

1.3. Босоо шугаманд хэсэглэх газарт галт тэрэг ирсэн, явсан, өнгөрсөн цаг минутыг тэмдэглэх бөгөөд арав, арван минутын зайтай байна. Зурмагийн цагийг 10 минутаар 6 хуваасан байх ба 30 минут тус бүр нь тасархай зураасаар, цаг бүр нь тод хар зураасаар, бусад нь нарийн хар зураасаар хуваагдсан байна. Хэвтээ шугамд хэсгийн, ялгалтын, техникийн өртөөдийн тэнхлэгийг тодоор, зөрлөгүүдийг бүдгээр тус тус тэмдэглэнэ.

1.4. Зурмагт галт тэрэгний хөдөлгөөнийг явалтын шугам /нитка/ гэж нэрлэгдэх ташуу шулуун шугамаар тэмдэглэнэ.

1.5. Галт тэрэгний хэсэглэх газарт ирсэн, явсан, шууд өнгөрсөн хугацааг зурмагт явалтын шугам нь хэвтээ тэнхлэгтэй огтлолцсон цэгээр тогтооно.

1.6. Явалтын шугам ба хэсэглэх газрын тэнхлэгт үүссэн мохоо өнцөгт галт тэрэгний ирсэн явсан зогсолтгүй өнгөрсөн хугацааг бичнэ. Галт тэрэг хэсэглэх газраар зогсолтгүй өнгөрөх үед зөвхөн тэндээс явсан цагийг бичнэ. Хэрэв явалтын шугам өртөөний тэнхлэгийн цаг, минутын шугамтай давхацвал мохоо өнцөгт 0 (тэг) тавина.

1.7. Зурмаг нь тэгш, сондгой ачаа, ачилт, буулгалт, хоосноор байгаа вагонуудыг болон өртөөний жижүүрүүдийн нэрсийг дэд бүтэц эзэмшигчийн тогтоосон ажлын цагийн хуваарьт тохирсон хүснэгттэй байна.

1.8. Галт тэрэгний төрөл тогтоосон дугаарлалтыг тэгш ба сондгой чиглэл бүрд өгнө. Тэгш дугаарыг гол замын километрийн өсөлтийн чигт, эсрэг чиглэлд сондгой тоогоор төгссөн дугаарыг олгоно.

1.9. Зурмагийн хавсралтад өртөөдөөс явсан галт тэрэгний гол ба вагоны тоо, бүрэлдэхүүний төрөл, ачаатай ба хоосон цэвэр бохир жин, галт тэрэгний дугаар, машинчийн нэр, дуудагдсан ба контрольд гарсан цаг, явсан цаг, галт тэрэгний сүүлийн вагоны дугаар, томъёолсон урт бичихэд зориулагдсан хүснэгтүүдтэй байна. Программ хангамжтай бол цахим байдлаар бүртгэж байж болно.

1.10. Зурмагт тухайн хэсгийн бүх өртөө, зөрлөг ба зэргэлдээх хэсгийн хилийн болон уулзварын өртөөдийн нэрсийг бичсэн байх ба салаалсан хоорондын замыг тусдаа доод хэсэгт салгаж хэвлэсэн байвал зохино.

1.11. Зурмагийн хавсралтад ДО-2-р үзүүлсэн вагонуудыг өртөөдөөр нь бичээд төрөл, явсан, ачилтанд, үлдэгдлээр нь бичихэд зориулагдсан хүснэгттэй байна. Программ хангамжтай бол цахим байдлаар бүртгэж байж болно.

1.12. Хэсгийн хэмжээнд байгаа тэгш, сондгой чиглэлийн ачааны үлдэгдлийг бичих тэгш, сондгой гэсэн бичиглэлтэй байна.

1.13. Зурмагийн хавсралтад өртөөдөөс явах галт тэрэгний дугаар, зүтгүүрийн дугаар, машинчийн нэр, дуудагдсан цаг, контролын цаг, явсан цаг, вагоны төрөл, ачаатай хоосон цэвэр бохир жин, сүүлийн вагоны дугаар, томьёолсон урт зэргийг бичнэ. Программ хангамжтай бол цахим байдлаар бүртгэж байж болно.

1.14. Хоногийн ДО-2-р үзүүлсэн хоосон вагонуудыг явсан, ачилтанд авсан, үлдэгдлээр нь тооцож төрлөөр нь ялгаж бичнэ. Программ хангамжтай бол цахим байдлаар бүртгэж байж болно.

ХОЁР. ЗУРМАГ ХӨТЛӨХ

2.1. Зурмагт эхлээд 17.00 цагаар хэсэгт аялж байгаа бүх галт тэргүүдийг шилжүүлж зурах ба зорчигчийн галт тэргүүдийг батлагдсан зурмагийн дагуу хуулж бичнэ.

2.2. Галт тэрэгний диспетчер нь хоногийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу галт тэрэгнүүдийг урьдчилан зурж төлөвлөнө.

2.3. Галт тэрэгний ахлах диспетчер хоногийн ажлын төлөвлөгөөний арын хүснэгтийг гүйцэтгэлийн дагуу бөглөнө.

2.4. Явах галт тэргийг дугаарлаж зүтгүүрийн дугаар, вагоны тоо, бохир жинг алдаагүй зөв бичиж тэмдэглэнэ.

2.5. Галт тэргийг өртөөдөөс явахаас өмнө бичих ба явсан галт тэргүүдийг өнгийн бал эсвэл харандаагаар тодруулж зурна. Өртөөнөөс явсан, өртөөгөөр өнгөрсөн цагийг тэмдэглэхдээ 10 минутаас бага бол зураасны дотор талд нь минутыг тэмдэглэнэ.

2.6. Зурмагт галт тэрэгнүүдийг төрлөөс нь хамааруулан дараах өнгөөр тэмдэглэнэ:

2.6.1. Бүх төрлийн зорчигчийн галт тэргийг улаан;

2.6.2. Шууд дамжин өнгөрөх ачаатай галт тэргийг хөх;

2.6.3. Хоосон вагонуудтай галт тэргийг ногоон;

2.6.4. Орон нутгийн ачаатай галт тэргийг хүрэн;

2.6.5. Вагонгүй зүтгүүр ба хүйтэн тэргийг дан зураасаар;

2.6.6. Аж ахуйн галт тэргийг хар өнгийн зураасаар зурж шар өнгө дагуулж тэмдэглэнэ /мотовоз, дрезин, зам хэмжигч гэх мэт/;

2.6.7. Ачаатай думпкар, хоппер, дозатор гэх мэт вагонуудтай аж ахуйн галт тэргийг хүрэн өнгөөр зурж шар өнгө дагуулж тэмдэглэнэ;

2.6.8. Хоосон думпкар, хоппер, дозатор гэх мэт вагонуудтай аж ахуйн галт тэргийг ногоон өнгөөр зурж шар өнгө дагуулж тэмдэглэнэ;

2.6.9. Сэргээн босгох ба галын галт тэрэгнүүдийг хос улаан зураасаар;

2.6.10. Усны галт тэргийг тасархай /дундаа хэрээстэй/ зураасаар бал буюу үзгээр зурж шар өнгө дагуулж тэмдэглэнэ;

2.6.11. Засгийн газрын тушаалаар аялах ачааны галт тэрэг болон хатуу зурмагийн галт тэргийг хүрэн өнгөөр зурж улаан дагуулан дугуй дотор таван хошуугаар тэмдэглэнэ;

2.6.12. Ачаатай чингэлгийн галт тэргийг хөх өнгөөр зурж улаан өнгө дагуулж тэмдэглэнэ;

2.6.13. Хоосон чингэлэгтэй галт тэргийг ногоон өнгөөр зурж улаан өнгө дагуулж тэмдэглэнэ.

2.7. Өртөөдөөс сүүлчийн дохио, вагоны дугаар шалгасан тухай илтгэлийг хэсгийн өртөөдөд гурвалжин улаанаар тэмдэглэнэ.

2.8. Хоногийн ажлын төлөвлөгөөнд цагийн тасалдал гарсан тохиолдол бүрт буруутай, саатуулсан нэгжийн нэрийн товчлолыг хөх дугуй дотор улаанаар бичиж тэмдэглэгээ хийнэ.

2.9. Зам засварын ажилд зориулсан цонхыг хоорондын зам, өртөө, суман шилжүүлэг зэргээр нь өгөгдсөн хугацаагаар нь улаанаар тэмдэглэж “Цонх” гэж бичнэ.

2.10. Хөдлөх бүрэлдэхүүнээр эзлүүлсэн завсрын өртөөдийн замыг хаасан тухай тэмдэглэлийг улаанаар тэмдэглэж замын ба ивүүрийн дугаарыг бичнэ.

2.11. Галт тэрэг хүлээж авч өнгөрүүлсэн замын дугаарыг галт тэрэг ирэх чиглэлийн дагуу ромбо тоогоор тэмдэглэнэ.

2.12. Машинч нар аяллын төгсгөлд график нийлсэн тухайд дармал “Н” үсгээр тэмдэглэнэ.

2.14. Хоорондын замд галт тэрэг явах хугацаанаасаа илүү эсвэл дутуу явсан бол зөрүүтэй хугацааны өмнө +, - тэмдгийн ард хугацааг тавина.

2.15. Орох дохионы өмнө зогссон зогсолтыг “З” үсгээр тэмдэглэж хугацааг заан хөх өнгөөр бичнэ.

2.16. Эргэлтийн депо дахь зүтгүүрийн зогсолтыг улаан сумтай зураасаар тэмдэглэнэ.

2.17. Завсрын өртөөдөд залгаж, салгасан вагоныг ачаатай, хоосон төрлөөр нь бичиж цааш аялах галт тэрэгний вагоны тоо, цэвэр бохир жин, сүүлийн вагоны дугаарыг бичиж тэмдэглэнэ.

2.18. Галт тэргийг найруулсан өртөөнөөс бичиг баримтын цүнхтэй явсан тухай тэмдэглэлийг тэгш өнцөгт дотор гурвалжин улаанаар тэмдэглэнэ.

2.19. Цахилгаан гэрэл тасарсан тохиолдолд өртөө ба хоорондын замыг хөхөөр, ХАХ гэмтсэн ба бүх төрлийн холбоо тасарсан бол улаан өнгөөр будаж шалтгааныг бичнэ.

2.20. Урт бүрэлдэхүүнтэй галт тэргийг “У” үсгээр, тэсрэх дэлбэрэх ачаатай галт тэргийг “Т” үсгээр, химийн аюултай ачаатай галт тэргийг “ХА” үсгээр, хэтрүү овортой ачаатай галт тэргийг “ХО” гэсэн үсгүүдээр тэмдэглэгээ хийж оврын зэргийг зааж улаан өнгөөр бичнэ.

2.21. Зүтгүүрийн жингийн нормоос илүү жинтэй, түлхэлт шаардагдах хүнд жинтэй галт тэргийг улаан дарцгаар тэмдэглэж бохир жинг бичнэ.

2.22. Хэрэв галт тэрэг хоорондын замд саатаж зогсвол түүнийг зогссон мөчөөс явах мөч хүртэл нь улаанаар тэмдэглэж, зогссон хугацааг тэмдэглэнэ.

2.23. Галт тэргийг өртөөнд орж ирснийг тэмдэглэснээс хойш явах цаг хүртэл нь замын дугаарыг тавьж үзгээр холбож тэмдэглэнэ. Хэрэв галт тэрэг явалгүйгээр дараа хоногийн зурмагт шилжвэл түүнийг үргэлжлүүлэн тэмдэглэнэ.

2.24. Өртөөд дээр ирсэн галт тэрэгний бүрэлдэхүүнд сэлгээ хийх үед үзгээр долгионтуулж тэмдэглэлийг хийнэ.

2.25. Ажиллагаатай галт тэргийг өртөөнд орж ирсний дараа үзгээр тэмдэглэн сум зааж “А” үсэг тавина. Уг галт тэргийг найруулж дуусаад явуулах замд нь тавьсан мөчөөс нь эхлэн “ДА” үсэг тавьж баганатай зураасаар тэмдэглэнэ.

2.26. Өртөөдийн замын байдлыг 20.00, 08.00 цагаар өртөөдөөс авч бүх тэгш сондгой ачааны нийлбэр, ачааны төрлийг тэмдэглэх ба хэсэгт ачааны галт тэргэнд ажиллаж байгаа зүтгүүрүүдийн дугаарыг зориулалтын хүснэгтэд бичиж тэмдэглэнэ.

2.27. Хэсгийн өртөөдийн замын байдлыг 08.00, 20.00 цагийн байдлаар авахдаа ачаатай бол чиглэлийг зааж “Т”, “С” гэсэн тэмдэглэгээ хийж хүрэх өртөө, вагоны тоог бичнэ.

2.29. Галт тэрэгний диспетчер нь хэсэгт аялсан галт тэрэг бүрийн хэсгийн хурдыг бодож тэмдэглэнэ.

ГУРАВ. ЗУРМАГ БОЛОВСРУУЛАХ ҮНДСЭН ӨГӨГДӨЛ

Дэд бүтэц эзэмшигч нь галт тэрэгний хөдөлгөөний зурмагийг боловсруулахдаа Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмыг баримтлана.

Хөдөлгөөний зурмагийг боловсруулахын өмнө тухайн замын чанарын үндсэн үзүүлэлтийн норм өгөгдсөн байна. Үүнд: техникийн, хэсгийн болон замналын хурдууд, зүтгүүрийн хоногийн дундаж гүйлт хамаарна.

Зурмаг боловсруулахад дараах зарчмыг баримтална.

1. Эхлээд алсын харилцааны болон орон нутгийн зорчигчийн галт тэрэг, дараа нь ачааны хурдавчилсан галт тэргийг байрлуулна.

2. Тухайн хэсэг чиглэлд орон нутгийн ажлыг зохион байгуулах, системийн дагуу замын хэмжээний галт тэрэгний хөдөлгөөний болон зүтгүүрийн эргэх хэсгийн загвар боловсруулна.

3. Энэ схемд тохируулан зурмагийг хэсэг бүрээр байгуулна.

4. Хэсэг бүрээр байгуулсан зурмагийг хооронд нь галт тэрэгний явалтын хугацаа, өртөөдөд ирэх интервалд тохируулан уялдуулна.

Зурмаг зохиоход дэд бүтэц эзэмшигчийн баталсан дараах материалуудыг үндэслэнэ.

Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан нэгжээс:

- Өртөөдийн техник захирамжийн акт, технологийн процесс;
- Галт тэрэгний жингийн норм, ачаа зорчигчийн галт тэрэгний хурд, хоорондын замд явах хугацааны тушаалууд;
- Ачилт буулгалтын төлөвлөгөө;
- Галт тэрэгний хөдөлгөөний диспетчерүүдийн баримталж ажиллах материалууд;
- Вагоны техникийн үзүүлэлтүүд;
- Тормос шалгах, техник үзлэг хийх журмууд;
- Зэргэлдээ замаас авах, өгөх ачааны хэмжээ;
- Сар, улирлын ачилтын захиалга;
- Хилийн хэлэлцээрийн протокол;
- Галт тэрэгний диспетчер нарын баримталж ажиллах материалууд.

Зүтгүүрийн аж ахуй хариуцсан нэгжээс:

- Ашиглах зүтгүүрүүдийн техникийн үзүүлэлтүүд;
- Үндсэн ба эргэлтийн депогийн ажлын хугацаа, машинч туслах нарын байршил;
- Засваруудын хугацаа.

Замын аж ахуй хариуцсан нэгжээс:

- Бүх өртөө зөрлөг хоорондын замын урт, хэвгий, зам төмөр, сумын марк, төрөл, тахирын радиус зэрэг үзүүлэлтүүд;
- Замын засварын ажлын төлөвлөгөө;
- Галт тэрэгний хурд;
- Байнгын анхаарамж.

Дохиолол, холбоо хариуцсан нэгжээс:

- Бүх өртөө зөрлөгийн дохио, дохиолол холбооны тоног төхөөрөмжүүдийн заавар;
- Цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааны тухай заавар.

Зорчигч тээвэр хариуцсан нэгжээс:

- Зорчигчийн галт тэрэгний явуулалтын судалгаа, санал;
- Олон улсын галт тэрэгний хуваарь;
- Орон нутгийн зорчигчийн галт тэрэгний өртөө зөрлөг хоорондын замын зогсоолуудад зогсох хугацаа.

Зурмаг боловсруулах үндсэн өгөгдөлд:

- Өртөөнд зогсох зогсолт ба хоорондын замд явах хугацаагаар ялгагддаг зорчигчийн болон ачааны галт тэрэгний төрөл тэдгээрийн хэмжээ;
- Хөдөлгөөний зурмагийн элементүүд болон ялгалтын, хэсгийн өртөөнд задрагдахаар ирэх галт тэрэг хоорондын технологийн интервал, тэдгээр өртөөдөөс найруулан явуулах галт тэрэгний интервал;
- Өртөөдөд ойртох хэсгийн замын хэвгийн тодорхойлолт;
- Галт тэрэг найруулах төлөвлөгөө;
- Зарим хэсгүүдэд болон чиглэлд бүхэлд нь орон нутгийн ажил зохион байгуулах систем, завсрын өртөөдөд түүвэр галт тэрэгний ажиллах хугацааны норм;
- Зүтгүүр эргэх хэсэг, зүтгүүрийн бригад солих болон бүрэлдэхүүнд техникийн үзлэг хийх өртөөд;
- Галт тэрэгний зүтгүүрийн бригадын тасралтгүй ажиллах хугацааны норм;
- Замд засварын ажил хийхээр “цонх” гаргах даалгавар зэрэг болно.

ДӨРӨВ. ЗУРМАГИЙН БИЕЛЭЛТ ТООЦОЖ БҮРТГЭХ

4.1. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг тооцох анхдагч бичиг баримт нь:

4.1.1. Төмөр замын өртөөдөд:

- Өртөөний ажлын ээлжийн төлөвлөгөө;
- Галт тэрэгний хөдөлгөөн бүртгэх дэвтэр;
- Төмөр замын өртөөний ажлын гүйцэтгэсэн зурмаг;
- Зорчигчийн галт тэрэгний цагийн хуваарь ба түүний аяллын нөхцөлийн өөрчлөлт;
- Галт тэрэгний диспетчерийн тушаалууд;

- Төмөр замын өртөөний ажлын технологийн горим.

4.1.2. Дэд бүтэц эзэмшигч байгууллагад:

- Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмаг;
- Диспетчерийн хуваариар аялах галт тэрэг ба зорчигчийн галт тэрэгний хуваарь эсвэл түүний аялах нөхцөлийн өөрчлөлтийн тухай заалт;
- 4-6 цагийн үелзэлтэйгээр тохируулга хийсэн галт тэрэгний диспетчерийн ээлжийн ажлын төлөвлөгөө;

4.2. Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн өгөгдлүүд:

- Дамжин өнгөрөх галт тэрэгний – Хилээр тухайн төмөр замд орж ирсэн ба хүрэх өртөөнд ирсэн хугацаа;
- Бусад замаас тухайн замд ирж аялал нь дуусах галт тэрэг – Тухайн замд орж ирсэн ба хүрэх өртөөнд ирсэн хугацаа;
- Диспетчерийн хуваариар аялах зорчигчийн ба бусад галт тэргийг томилсон, тэдгээрийн аялах нөхцөлийг өөрчилсөн заалт;
- Тухайн замаас аялалаа эхлэх галт тэрэг – Өртөөнөөс явуулсан ба зэргэлдээ төмөр замд хүлээлгэн өгсөн хугацаа эсвэл тухайн замын хүрэх (эргэлтийн) өртөөнд ирсэн хугацаа;
- Нөхөлт хийх тухай галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн бүртгэл тушаал.

4.3. Хуваариас хоцорсон галт тэргийг зурмагт оруулах зорилгоор түүний хоцролтыг багасгах хамгийн дээд хугацааг тусгасан байна. Галт тэрэгний хоцролтыг багасгах хамгийн бага норм нь диспетчерийн хэсэг дэх галт тэрэгний нийт хугацаанаас 5 хувь, харин ачааны ба зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөний зэрэгцээ зурмагтай хэсэгт 10 хувиас багагүй байхаар тусгасан байна.

4.4. Дэд бүтэц эзэмшигч байгууллага нь галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн биелэлтэд хийгдэх анхдагч тооцоог маягт ДУ-26 /зорчигчийн/ ба маягт ДУ-27 /ачааны/-г үндэслэн гүйцэтгэнэ.

Эдгээр маягтуудад:

- Найруулсан өртөөнөөс галт тэрэг явуулсан хугацаа;
- Хүрэх эсвэл задрагдах өртөөнд галт тэрэг ирсэн хугацаа;
- Зэргэлдээх диспетчерийн хэсгээс /дэд бүтцээс/ галт тэрэг ирсэн хугацаа;
- Зэргэлдээх диспетчерийн хэсэгт /замд/ галт тэрэг хүлээлгэн өгсөн хугацаа;
- Галт тэрэг хоцорсон нийт хугацааг түүнд хамаарах шалтгааны хамт бүртгэнэ.

Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагт хийх шинжилгээг замын хувьд хариуцсан нэгжийн ажилтан, нийт замуудын хувьд Төмөр замын нэгдсэн удирдлага, зохицуулалтыг хариуцсан байгууллага гүйцэтгэнэ.

Шинжилгээний дүнг алба, хэлтсийн удирдлага судалж галт тэрэг саатсан, баригдсан шалтгааныг тодруулан хойшид ийм зөрчил гаргахгүй байх шуурхай арга хэмжээг авна.

4.5. Ялгалтын, хэсгийн, томоохон өртөөдөд өөрөөс найруулсан галт тэрэгний явуулалт ба дамжин өнгөрөх галт тэргийг зурмагаар нь явуулсан тухай тооцоог бүртгэж, өөрийн өртөөний ажилд шинжилгээ хийхэд ашиглана.

4.6. Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагт тооцоо, шинжилгээ хийхэд энэхүү зааврыг болон тооцоо шинжилгээ хийх аргачлал, бусад нормчилсон бичиг баримтыг үндэслэнэ.

4.7. Галт тэрэгний хөдөлгөөний хоногийн ажлын төлөвлөгөө зурмагийг хугацаанд нь зохиох, галт тэрэг томилох ба галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах тухай диспетчерийн тушаалыг бүрдүүлэх, галт тэрэг ирсэн, явуулсан ба өнгөрүүлсэн өгөгдлийн үнэн зөвийг:

- Өртөөдөд - Өртөөний дарга
- Төмөр замын тээврийн байгууллагад - Тээвэрлэлт хариуцсан орлогч дарга хариуцна.

4.8. Галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагт хийсэн шинжилгээний чанар, тайлан тооцооны үнэн зөвийг:

Төмөр замын тээврийн байгууллагад – Зурмагийн дүн шинжилгээ хариуцсан нэгжийн дарга хариуцна.

4.9. Дэд бүтэц эзэмшигч улиралд нэгээс доошгүй удаа тооцооны хөтлөлт, тайлангийн бүрдүүлэлтийн үнэн зөв, бодит байдал болон энэ заавартай тохирч байгааг шалгана. Энэ үед галт тэрэгний гүйцэтгэсэн зурмагийн хөтлөлтийн үнэн зөв түүний чанар тооцооны маягт дахь өгөгдөл галт тэрэгний хөдөлгөөн бүртгэх дэвтэр, машинчийн замналын хуудас ба хурд хэмжигч туузны орчуулгатай хэрхэн тохирч байгаа, мөн түүнчлэн галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд хийсэн шинжилгээнд онцгой анхаарах ёстой.

Хэрэв галт тэрэгний хөдөлгөөн бүртгэх дэвтэрт бичигдсэн өгөгдөл галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмагийн өгөгдөлтэй тохирохгүй бол хурд хэмжигч туузны оруулгыг үндэс болгон авна. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн өгөгдөл хурд хэмжигч туузны оруулга хоорондын зөрүү 2 минутаас ихгүй байхыг зөвшөөрнө.

4.10. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг тооцох нэгж нь галт тэрэг болно.

4.10.1. Ачааны ба зорчигчийн галт тэрэгний явуулалтаар:

- Хуваариар (зурмагаар) явуулсан;
- Хоцорч явсан (явуулсан);

4.10.2. Ачааны ба зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлтээр:

- Хуваариар (зурмагаар) өнгөрүүлсэн;
- Хоцролтыг багасгаж өнгөрсөн;
- Хоцролттой өнгөрсөн;

4.10.3. Зорчигчийн галт тэрэгний ирэлтээр:

- Хуваариар (зурмагаар) ирсэн;
- Хоцорч ирсэн;

4.11. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг тооцох:

4.11.1. Зорчигчийн ба орон нутгийн, ачаа зорчигчийн, жуулчны галт тэрэг;

- Найруулсан (эргэлтийн) өртөөнөөс-явуулалтаар;
- Диспетчерийн хэсгийн хилээр ба төмөр замаар-өнгөрүүлэлтээр;
- Хүрэх (эргэлтийн) өртөөнд-ирэлтээр;

4.11.2. Ачааны галт тэрэг:

- Найруулсан өртөөнөөс - явуулалтаар;
- Диспетчерийн хэсгийн хилээр - өнгөрүүлэлтээр;

4.12. Зорчигчийн ба ачааны галт тэрэгний зурмагийн биелэлтийн үндсэн үзүүлэлтүүд:

- Зурмагаар явуулсан галт тэрэгний хувь;

- Зурмагаар өнгөрүүлсэн галт тэрэгний хувь;
- Хоцролтыг багасгаж өнгөрүүлсэн галт тэрэгний хувь;
- Хүрэх өртөөнд зурмагаар ирсэн зорчигчийн галт тэрэгний хувь;

4.13. Зорчигчийн ба ачааны галт тэрэгний тооцоог найруулсан өртөөнөөс галт тэрэг хүрэх өртөө (задрагдах, эргэлтийн) хүртэл аялсан бүх замын туршид диспетчерийн тойргийн эхний ба эцсийн өртөөнд мөн түүнчлэн хэсгийн, ялгалтын өртөөд, замууд хоорондын уулзварын өртөөдөд байсан хугацааг тооцон тасралтгүй хөтөлнө.

4.14. Найруулсан өртөөнөөс явуулж байгаа бүх галт тэргэнд, харин зорчигчийн ба галт тэрэг эргэх өртөөнөөс зурмагт тохирсон дугаар өгөх бөгөөд эдгээр нь хүрэх болон задрагдах, эргэх өртөө хүртэл эсвэл тухайн галт тэрэгний хуваарь нь дуусах өртөө хүртэл аялах бүх замын турш хэвээр хадгалагдана.

Диспетчерийн хуваариар явуулсан ачааны галт тэрэгний дугаар нь 4 – 6 цагийн үелзэлтэйгээр тохируулга хийсэн ээлжийн ажлын төлөвлөгөөтэй тохирч байвал зохино.

Диспетчерийн хуваариар аялуулах нэмэгдэл галт тэргэнд галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгагдсан тухайн төрлийн галт тэрэгний сүүлчийн дугаарын дараах дугаарыг олгоно.

4.14.1. Зорчигчийн галт тэрэгний дугаар галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгагдсан өртөөнд тэгшээс сондгойд, эсвэл эсрэгээр өөрчлөгдөнө.

4.14.2. Ачааны галт тэргэнд дугаараас гадна индекс олгох бөгөөд тэр нь галт тэрэг хүрэх болон задрагдах өртөө хүртэлх бүх замын турш өөрчлөгдөхгүй. Дугаар ба индексийг галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмаг, галт тэрэгний хөдөлгөөн бүртгэх дэвтэр, галт тэрэгний биечилсэн хуудсанд заана.

4.14.3. Төрөл бүрийн галт тэрэгний дугаар, хуваарийг албан хэрэгцээнд зориулан гаргана. Галт тэргэнд олгосон дугаар ба индекс нь тооцооны хоногийн турш дахин давтагдахгүй.

4.14.4. Ачааны дамжин өнгөрөх галт тэргэнд шинэ дугаар олгоно. Үүнд:

- Хэсгийн (ялгалтын) өртөөнд цагаараа ирж, энэ өртөөнд бүрэн задарсан эсвэл энэ галт тэрэгний цаашид аялах чиглэл нь өөрчлөгдсөн үед,
- Галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагоны талаас илүү хувийг сольсон эсвэл нэмэгдүүлсэн үед,
- Шинэ дугаарыг галт тэрэгний хөдөлгөөний гүйцэтгэсэн зурмаг, галт тэрэгний хөдөлгөөн бүртгэх дэвтэр, галт тэрэгний биечилсэн хуудсанд бичнэ.

4.14.5. Ачааны дамжин өнгөрөх галт тэрэгний дугаар ба индексийг өөрчлөхийг хориглоно. Түүнээс техникийн болон коммерийн гэмтэлтэй вагон салгаснаас бусад шалтгаанаар галт тэрэгний бүрэлдэхүүний талаас илүү хувийг сольсон эсвэл нэмэгдүүлсэн тохиолдолд түүнийг өөрөөс найруулсан галт тэргэнд тооцно.

4.14.6. Ачааны галт тэргэнд түүний төрөл, чиглэл тохиороогүй дугаар олгохыг хориглоно.

4.15. Дараах тохиолдолд диспетчерийн хуваариар галт тэрэг явуулахыг зөвшөөрнө. Үүнд:

- Овортой ачаатай эсвэл галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгагдсантай харьцуулахад хурд хязгаарлах шаардлагатай хөдлөх бүрэлдэхүүнтэй үед;
- Галт тэрэгний ээлжийн ажлын төлөвлөгөөнд явуулахаар төлөвлөсөн галт тэрэгний тооноос зурмаг дахь “явалтын шугам”-ийн тоо бага үед;
- Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт тусгай “явалтын шугам” тусгаагүй тохиолдолд урт бүрэлдэхүүнтэй ачааны галт тэрэг өнгөрүүлэхэд;

- Дэд бүтэц эзэмшигчийн тогтоосон журмаар галт тэрэгний хөдөлгөөний зуны болон өвлийн, эсвэл шинэ, мөн түүнчлэн тохируулга хийсэн зурмагт шилжих үед;

Диспетчерийн хуваариар аялах ачааны галт тэрэг нь зөвшөөрөгдсөн хурд, зүтгүүрийн бригадын ажлын дэглэмийг мөрдөхөөр зохион байгуулагдах ба диспетчерийн захирамжийн дэвтэрт бүртгэгдсэн тушаалаар танилцуулагдан галт тэрэг явуулахаас 30-аас доошгүй минутын өмнө өртөөний (сэлгээний) диспетчер, өртөөний жижүүр галт тэрэгний машинч мөн түүнчлэн зэргэлдээх диспетчерийн хэсэгт дамжуулагдсан байна.

4.16. Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөнийг ачааны галт тэрэгний явалтын хугацаагаар (зэрэгцээ зурмаг) галт тэрэгний хөдөлгөөний зурмагт байршуулсан төмөр замын хэсэгт зорчигчийн галт тэргийг цуцалсан эсвэл хоцорсон тохиолдолд зорчигчийн галт тэрэгний хуваариар ачааны галт тэрэг аялуулах ба өнгөрүүлэхийг зөвшөөрнө. Энэ тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг зорчигчийн галт тэрэгний хуваарийг үндэслэнэ.

4.17. Зорчигчийн галт тэрэгний хуваариар ачааны галт тэргийг явуулах тохиолдолд зэргэлдээх хэсгийн диспетчертэй зөвшилцөж галт тэрэгний ээлжийн ажлын төлөвлөгөөнд тусгасан байна.

4.18. Төмөр замын нэг замт хоорондын зам, хос ба олон замт хэсгийн нэг эсвэл хэд хэдэн гол замын галт тэрэгний хөдөлгөөнийг түр хугацаагаар “цонх” гарган хааж зам, засварын ба барилга угсралтын ажил гүйцэтгэх шаардлагатай үед мөн түүнчлэн урьдчилан мэдэгдээгүй байдал үүссэн үед (онцгой шаардлагаар томилж өнгөрүүлэх галт тэрэг, хоорондын замын хөдөлгөөний хэвийн ажиллагааг сэргээхээр дугаар харгалзахгүй аялуулах сэргээн босгох, галын галт тэрэг, цас цэвэрлэгч, ганц зүтгүүр, автоматрис ба замаас авагддаг дрезин) ачааны галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтийг боловсруулсан зурмагийн хувилбар эсвэл төмөр замын хилээр галт тэрэгний аялах хуваарьт өөрчлөлт орсон үед дэд бүтэц эзэмшигчийн баталсан өөрчлөлтийг үндэслэн тооцно.

ТАВ. ЗУРМАГИЙН ТАЙЛАН

5.1. Галт тэрэгний явуулалт ба өнгөрүүлэлтээр баригдаж ирсэн хугацааг дэд бүтэц, салбар нэгжээр нэгтгэж хоног, сараар гаргана.

5.2. Галт тэрэгний гүйцэтгэсэн зурмагт өдөр бүр шуурхай шинжилгээ хийж дүнг тайлангийн хугацааг дууссанаас хойш 2-оос доошгүй цагийн дотор дэд бүтэц эзэмшигчийн удирдлагад мэдэгдэнэ.

Галт тэрэгний өнгөрүүлэлтэд хийсэн шинжилгээний дүнг үндэслэн тээвэрлэлтийн үйл ажиллагааны биелэлтийг зохих маягтын дагуу мэдэгдэнэ.

5.3. Зорчигчийн ба ачааны галт тэрэгний зурмагийн биелэлтийн тайланг замаар нэгтгэн сар бүр ДО-12 маягтын дагуу тухайн дэд бүтэц эзэмшигч байгууллагын зурмагийн дүн шинжилгээ хариуцсан нэгж гаргана. ДО-12 тайлангийн маягад зорчигчийн ба орон нутгийн, ачааны галт тэргийг диспетчерийн хэсгүүдээр тусгана. Тайланд зурмагийн дүн шинжилгээ хариуцсан ажилтан гарын үсэг зурж тайлангийн хугацаа дууссанаас хойш 16 цагийн дараа дэд бүтэц эзэмшигч байгууллагын удирдлагад мэдэгдэнэ.

Диспетчерийн хэсгүүдээс нэгтгэсэн галт тэрэгний явуулалт, өнгөрүүлэлтийн биелэлтийн дүнг галт тэрэгний хөдөлгөөний диспетчер, өртөөдөд өртөөний жижүүр, сэлгээний диспетчерийн ажилд үнэлэлт дүгнэлт өгөхөд ашиглана.

5.4. Олон улсын зорчигчийн болон дамжин өнгөрөх галт тэрэгний хөдөлгөөний өнгөрүүлэлтийн биелэлтийн тооцоонд дараах өгөгдлийг ашиглана.

- Тухайн дэд бүтцэд аялал нь дуусч байгаа галт тэрэгний өртөөнд ирсэн бодит цагийг зорчигчийн галт тэрэгний зурмаг шинжилгээний маягт ДУ-27 дагуу;
- Галт тэрэг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хугацаа, хоцорсон цаг, минутыг замын өгөгдлөөр;
- Хоцорсон галт тэргийг хүлээлгэн өгсөн хугацааг зам хоорондын уулзварын өртөөний цахилгааныг үндэслэж тооцно.

Дэд бүтэц хоорондын уулзварын өртөө нь хоцрогдолтой өнгөрүүлсэн галт тэрэгний талаар тооцооны хоног дууссанаас хойш 1 цагийн дотор зэргэлдээх дэд бүтцийн Тээвэр зохион байгуулалт хариуцсан нэгжид мэдэгдэнэ. Үүнд:

- Галт тэрэгний дугаар
- Замд орж ирсэн хугацаа
- Хүлээлгэн өгсөн хугацаа

Дээрх мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг дамжуулсан замын тээвэр зохион байгуулалт хариуцсан нэгж хангах бөгөөд хүлээн авсан зам энэ мэдээллийг үндэслэж хоногийн тайланд тодотгол хийнэ.

5.5. Маягт ДО-12-т бүртгэгдсэн зорчигчийн болон ачааны галт тэрэгний тайланг тайлангийн хугацаа дууссанаас хойш 16 цагийн дараа Төрийн захиргааны төв байгууллагын харьяа Төмөр замын байгууллагад /ГТХЗНТ/ явуулна. Тайланд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

5.5.1. Галт тэрэгний явуулалтаар:

- Явуулсан галт тэрэгний тоо: (Үүнээс хуваариар явуулсан):
- Хуваариар явуулсан галт тэрэгний эзлэх хувь,
- Явуулалтаар хоцорсон галт тэрэгний нийт хугацаа (цаг)

5.5.2. Галт тэрэгний өнгөрүүлэлтээр:

- Өнгөрүүлсэн бүх галт тэрэгний тоо: (Үүнээс хуваариар өнгөрүүлсэн, хоцролтыг багасгасан);
- Өнгөрүүлэлтээр хоцорсон бүх галт тэрэг: (Үүнээс технологийн онцгой шаардлагаар хоцорсон);
- Хуваариар өнгөрүүлсэн галт тэрэгний эзлэх хувь;
- Өнгөрүүлэлтээр хоцорсон галт тэрэгний нийт хугацаа (цаг).

5.6. Анхдагч тайлан, бүртгэлийн маягт түүний агуулга ба хөтлөх журмыг галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн бүртгэлийн тайлан, бүртгэлийн хөтлөх зааварт тусгасан болно.

ЗУРГАА. ЗУРМАГ ТООЦОХ

6.1. Ачааны галт тэрэгний явуулалт, өнгөрүүлэлтийн зурмагийг дараах зааврын дагуу тооцож бүртгэнэ. Үүнд:

6.1.1. Ачааны галт тэрэгний явуулалт, өнгөрүүлэлт тооцох хэсэгт дэд бүтэц эзэмшигчийн баталсан хөдөлгөөний зурмаг, хоногийн ба ээлжийн ажлын төлөвлөгөөний дагуу явсан буюу өнгөрсөн галт тэрэгний зурмагийн дагуу явснаар.

6.1.2. Хэсгийн өртөөдөд хуримтлагдсан ачаа, хоосон вагоны урсгалын чиглэл, зүтгүүрийн хэрэгцээ, эргэлтийг харгалзан ачааны галт тэрэгний цагийн хуваарийг өөрчилсөн буюу шинээр төлөвлөсөн тухай Галт тэрэгний диспетчерийн тушаалын дагуу явсан буюу өнгөрсөн галт тэргийг зурмагийн дагуу явснаар.

6.1.3. Байгалийн онцгой үзэгдэл, давагдашгүй хүчин зүйл, хорио цээр болон бусад онцгой нөхцөлөөс шалтгаалан, баталсан хөдөлгөөний зурмаг, хоногийн ба ээлжийн ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан тухай дэд бүтэц эзэмшигчийн тушаал, цахилгааны дагуу явсан буюу өнгөрсөн галт тэргийг зурмагийн дагуу явснаар.

6.1.4. Хэсгийн өртөөнөөс ямар нэг шалтгаанаар хоцорч явсан буюу зүтгүүрийн техникийн байдлаас шалтгаалан хоорондын замд зогсоод хөдөлсөн үед галт тэрэгний диспетчерийн зохицуулалт, мөн машинчийн нөхөлтөөр хоцрогдлыг тухайн хэсэгтээ нөхөж, дараагийн хэсгийн өртөөнд цагтаа очсон галт тэрэгний өнгөрүүлэлтийг зурмагийн дагуу өнгөрснөөр.

6.1.5. Ачааны галт тэрэг 30 минут хүртэл хугацаагаар хэсгийн өртөөнөөс хоцорч явсан нь бусад галт тэрэгний цагийн хуваарьт нөлөөлөөгүй бол зурмагийн дагуу явсанд тооцно.

6.1.6. Ачаа болон зорчигчийн галт тэрэгний машинч нь төгсгөлийн өртөөнд ирээд галт тэрэгний диспетчертэй зурмаг нийлж, галт тэрэгний диспетчер зурмагийн дагуу ирсэн буюу зурмагийн тасалдал гарсан талаар тодорхой мэдээлэл өгч, өгсөн мэдээллийг галт тэрэгний машинч нь замналын хуудаснаа тэмдэглэж бичнэ.

6.1.7. Дээр дурьдсанаас бусад шалтгаанаар ачааны галт тэрэг хэсгийн өртөөнөөс цагийн хуваариас хоцорч явсан болон өртөөдөөр өнгөрөх цагийн хуваариас хоцорч өнгөрсөн бол зурмагийн тасалдлаар.

6.2. Хэсгийн өртөөд болон хэсэгт гарсан зурмагийн тасалдал нь хэд, хэдэн нэгжийн ажилтны буруутай үйл ажиллагааны улмаас бий болсон тохиолдолд эзлэх хувь, анхны шалтгаанаар галт тэргийг саатуулсан нэгжүүдэд зурмагийн тасалдлыг тооцох бөгөөд Зурмагийн биелэлтийг хянах байнгын комиссын шийдвэрээр буруутай салбар нэгжийг тогтооно.

6.3. Ачааны галт тэрэгний цагийн хуваарийг өөрчлөх тохиолдол бүрт зөвхөн галт тэрэгний диспетчерийн тушаалаар гүйцэтгэнэ.

6.3.1. Галт тэрэгний диспетчер нь ачааны галт тэрэгний явах цагийн хуваарийг өөрчлөх, төлөвлөх тухай тушаалыг үндсэн депод 3 цаг, эргэлтийн депод 1 цаг 30 минутаас багагүй хугацааны өмнө өгнө. Тушаалын үнэн зөв, зайлшгүй байдлыг тухайн галт тэрэгний диспетчер хариуцна.

6.3.2. Галт тэрэгний диспетчерийн өгсөн тушаалаар галт тэрэг яваагүй тохиолдолд зурмагийн дагуу яваагүй гэж үзэн тасалдлыг буруутай салбар нэгжид тооцно.

6.3.3. Галт тэрэгний диспетчер нь галт тэрэгний зүтгүүрийг Зүтгүүрийн депогоос гарахаас өмнө тус зүтгүүрт ажиллах машинчтай, зүтгүүр өртөөнд орж ирэхэд тухайн өртөөний жижүүртэй цагийг тохируулна.

ДОЛОО. ЗУРМАГИЙН ТАСАЛДАЛ БҮРТГЭХ

7.1. Гүйцэтгэж байгаа зурмагийн хөтлөлтийн хоногийн хугацаа 17:00 цагт дуусна. Хоногийн хугацаа дуусмагц зурмаг шинжээч инженер зурмагт дүн шинжилгээ хийж, холбогдох салбар нэгжээс

тодруулж, тасалдал гаргасан алба, салбар нэгжийг галт тэрэгний зурмагийн тасалдлыг бүртгэх программ хангамжид тэмдэглэнэ.

7.2. Дэд бүтэц эзэмшигч нар галт тэрэгний зурмагийн тасалдлын мэдээг сар бүрийн 5-ны дотор Төмөр замын нэгдсэн удирдлага, зохицуулалтыг хариуцсан байгууллагад ирүүлнэ.

7.3. Тасалдал гаргасан нэгж 3 хоногийн дотор ямар шалтгаанаар галт тэргийг саатуулсан, буруут этгээдэд хүлээлгэсэн хариуцлага, тасалдлыг дахин гаргахгүй байх талаарх авсан арга хэмжээний талаар Зурмаг шинжээч инженерт албан бичгээр ирүүлнэ. Маргаантай асуудал гарсан тохиолдолд комиссоор авч хэлэлцэн, комиссын буруутай шийдвэрээр буруутай салбар нэгжийг тогтооно.

7.4. Зурмаг шинжээч инженер нь зурмагийн тасалдалтай холбоотой материалыг сар бүрийн 05-ны болон 20-ны өдрөөр тасалбар болгож холбогдох нэгжтэй хамтран тулгаж, эцсийн дүнг нэгтгэн гаргаж, сар бүрийн 10-ны дотор комисст танилцуулах үүргийг хүлээнэ.

7.5. Хоцорч яваа галт тэргийг зурмагт нь оруулах тухай дэд бүтэц эзэмшигчийн тушаал, цахилгаан өгөгдөөгүй бол галт тэрэгний диспетчер тухайн галт тэргийг зурмагт нь оруулах гэж бусад галт тэргийг зурмагаас гаргахыг хориглоно. Харин хоцрогдолтой явж байгаа галт тэргийг бусад галт тэрэгний цагийн хуваарьт нөлөөлөхгүйгээр нөхүүлэх талаар санаачлагатай ажиллана.

7.6. Зурмагийн тасалдал гаргасан эхний галт тэрэгнээс шалтгаалж саатсан бусад галт тэрэгний зурмагийн тасалдлыг эхний тасалдал гаргасан буруутай салбар нэгжид нь тооцно.

7.7. Хамгаалалттай өртөө, гарам, гүүрийн хязгаарт галт тэргэнд мал дайрагдах, шүргэгдсэний улмаас галт тэрэг саатсан тохиолдолд малын эзэн хэн байхаас үл хамааран түүний харьяалагддаг салбар, нэгжид тасалдлыг тооцно.

7.8. Галт тэрэгний зурмагийн тасалдлыг бүртгэхдээ хамгаалалтгүй гарам дээр болон гарамгүй газарт галт тэргэнд авто машин, хүн, мал, ан амьтан дайрагдах буюу шүргэгдэх, техникийн хүчин зүйлээс шалтгаалсан болон байгалийн онц аюултай үзэгдэл (цас, бороо, аянга цахилгаан, хүчтэй цасан ба шороон шуурга г.м)-ийн улмаас галт тэрэг саатсан тохиолдолд “бусад” шалтгаанаар зурмагийн тасалдлыг тооцно. Үүнээс бусад тохиолдолд зурмагийн тасалдал гаргасан буруутай салбар нэгжид тасалдлыг тооцно.